



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 19 оны 03 дугаар
сарын 27 -ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлын төлбөрийн хэмжээ”-г нэгдүгээр хавсралтаар, “Менежментийн тогтолцоо (ISO9001, ISO14001 болон бусад)-ны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Баталгаажуулалтын зөвлөл, орон тооны бус аудитор, баталгаажуулалтын шинжээчийн ажлын хөлс, бусад зардлыг эрдэм шинжилгээний ажилтны зардлаас санхүүжүүлж байхыг Стандарт, хэмжил зүйн газар (Г.Гантөмөр)-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 106/314 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд



Ө.ЭНХТҮВШИН

0000040

Монгол Улсын Шадар сайдын
2019 оны 22 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын
ажлын төлбөрийн хэмжээ

Баталгаажуулалтын схемийн дугаар	Хөдөлмөр зарцуулалт /хүн- өдөр/ t_{Bi}	Баталгаажуулалтын ажлын төлбөрийн хэмжээ/төгрөг/	
		$B_{BB} = B_{BB(0)} \times t_{Bi}$	
		Улаанбаатар хот	Орон нутаг
Схем-1	3.77	155000	144600
Схем-2	3.8	156000	146000
Схем-3	4.3	177000	165000
Схем-4	5.07	209000	194000
Схем-5	3.36	138000	129000
Схем-6	3.33	137000	128000
Схем-7	1.07	44000	41000
Схем-8	1.92	79000	73700
Схем-9	2.27	93000	87000

---oOo---

Менежментийн тогтолцоо /ISO9001, ISO14001.../-ны баталгаажуулалтын
ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ

Д/д	Төлбөрийн төрөл	Төлбөрийн хэмжээ (мян.төг)
1	<p>Баталгаажуулалтын өргөдөл хүлээн авах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, шаардлагатай гэж үзвэл газар дээрх урьдчилан аудит багтана:</p> <p>Анхдагч баталгаажуулалт Давтан баталгаажуулалт Хамрах хүрээг өргөтгөх</p>	<p>120.0×K 100.0×K 80.0×K</p> <p>K- Менежментийн тогтолцооны төрлийн тооноос хамаарах коэффициент . 1 төрөл бол K= 1 2 төрөл бол K= 1.5 3 төрөл бол K = 2 4 төрөл бол K-2.5</p>
2	Аудитыг газар дээр нь явуулах	<p>$N \times D^* \times 120.0$ N- аудитын багт ажилласан аудитор, техникийн шинжээчийн тоо D - ажилласан өдрийн тоо. 120.0- газар дээр аудит хийх үйлчилгээний төлбөр(нэг хүн-өдөрт)</p>
3	Гэрчилгээ эзэмшүүлж, холбогдох стандартын тэмдэглэгээ хэрэглүүлэх үйлчилгээний жилийн төлбөр:	
	Тухайн байгууллагын ажиллагсдын тоо:	
	1-25	500.0
	26-86	600.0
	87-192	700.0
	193-353	800.0
	354-579	900.0
	580-880	1000.0
	881-1266	1100.0
	1267-1747	1200.0
	1748-2330	1300.0
	2331-3031	1400.0
	3032-3857	1500.0
	3858 ба түүнээс дээш	1600.0
4	Орон тооны бус - аудиторын ажлын хөлс (нэг хүн-өдөрт) - шинжээчийн ажлын хөлс (нэг хүн-өдөрт)	48.0 10.0
5	Үйлчлүүлэгч байгууллага нь аудитын багийн зам, байр, хоолны зардлыг хариуцна	

Тайлбар: D* - Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-аас гаргасан IAF MD 5 "Чанарын болон байгаль орчны аудитын хугацааг тогтооход мөрдөх баримт бичиг"-ийн дагуу тооцогдоно.